



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр


Дугаар 49


Улаанбаатар хот

Г Т
“Ноён даамал” ХЗХ-нд төсөл хөтөлбөрийг дамжуулан
хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 5.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 82 дугаар тогтоолын 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ноён даамал” ХЗХ-нд төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зөвшөөрлийн талаарх тэмдэглэгээг 2013 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор хийлгэхийг “Ноён даамал” ХЗХ /гүйцэтгэх захирал Д.Энхдэлгэр/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000000